

ИНТЕРНЕТ СЭТГҮҮЛ ЗҮЙ БА МЭДЭЭЛЛИЙН ДАЯАР НЭГДЭЛШИЛ

Б.Болд-Эрдэнэ*

* МУИС, НШУС, Сэтгүүл зүйн тэнхимийн багш, доктор, дэд профессор

Түлхүүр үг: Интернет, мэдээлэл харилцааны сүлжээ, виртуал ертөнц, технологийн нэгдэлшил, харилцааны орчин, тоон технологи

Интернет нь даян дэлхийн мэдээлэл харилцааны сүлжээ гэдэг утгаараа маш өргөн хүрээ, ахуй, эрэлт хэрэглээг нэгтгэсэн тогтолцоо юм. Тиймээс уламжлалт сэтгүүл зүйн үнэлэлт шалгуураар компьютерийг, өөрөөр хэлбэл, Интернетийг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл хэмээн үзэх нь нэлээд маргаантай болно. Үүний шалтгаан нь нэгдүгээрт, Интернет нь мэдээллийн гэхээсээ харилцаа сүлжээний эрэлт хэрэглээнд үйлчилдэг, хоёрдугаарт, олон нийтийн бус, хувь хэрэглэгчийн сонголт хайлтын хэрэгсэл болсон, гуравдугаарт, бизнес санхүү, худалдаа арилжааны үүрэг зорилго давамгайлж буй зэрэг хүчин зүйл тайлбарт оршино.

Гэхдээ даяар сүлжээ орчныг сэтгүүл зүй, сэтгүүлчид ашиглан, тодорхой нөхцөл хүрээнд олон нийтэд мэдээлэл түгээн, шинэ орон зай, боломж хэрэглээг бий болгон хөгжиж байгааг хүлээн зөвшөөрөх ёстой. Нийгмийн харилцаа, реклам сурталчилгаанд ч өөрчлөлт, хөдөлгөөн гарч, олон ний-

тийн санаа бодол, сэтгэл зүй, соёлд байр сууриа тэлсээр буйн жишээ баримт олон байна. Интернет сэтгүүл зүйн төлөөлөл жишиг болох мэдээллийн сайт нь үечлэл, давтамж, агуулга, хүртээмж, хэрэглээ зэргээрээ ОНМХ-ийн шинж чанарыг бүрэн тээн, сэтгүүл зүйн шинэ үзэгдэл хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох боллоо. Даян дэлхийн сүлжээгээр дамжуулан илүү олон хэрэглэгчдэд, эгшин зуурт, бүхий л сэдэв үйл явдлын мэдээллийг хаа сайгүй түгээх болсон юм. Мэдээж энэ бүхэн хэрэглэгчийн сонголт хүсэлт, хайлтаар, бодит үйл хэрэг, харилцаа болсноор шинэ давуу тал онцлогийг нээсэн.

Сэтгүүл зүйн үүсэн бий болсон цагаасаа эхлэн ямагт техник технологийн ололт амжилт, шинэчлэлийн үр жимс байсан, цаашид ч тийнхүү хөгжинө. Анхны сонин нь хэвлэх машины, радио нь долгион авагчийн, компьютер нь тоон технологийн нөлөө үр шимээр төрөн гарсан. Олныг үл өгүүлэн тоймлон дүгнэхэд энэ цагийн нийгмийн харилцаа, сэтгүүл зүйн бодитой хүч, хөдөлгөөр нь тоон технологи, түүнээ нэгтгэгдсэн хэрэгслийн төвлөрөл билээ. Америкийн судлаач Д.Беллийн "Үзэл суртлын төгсгөл" хэмээх

бүтээлийн гол санаа үзэл, технологийн мэдлэг, нөлөөнд эрхшээгдсэн шинэ нийгэмд нэг талаас мэдээлэл харилцааны технологи, нөгөө талаас түүний (материаллаг бус баялаг, үнэлэмжийн жишээ нь брэнд) үйлдвэрлэлийн өсөлт нь ирээдүйн эдийн засгийн тулгуур байх болно гэсэн нь өдгөө бодит зүйл, орчин үеийн хөгжлийн тайлбар, үндсэн зарчим бөлгөө.

Энэхүү нийгэм эдийн засгийн шинэ нөхцөл, өөрчлөлт ч мэдээллийн хэрэгсэл түүний хөгжил, өнөөгийн дүр зурагт нэвчин оршиж байна. Даяарчлал хэмээх дэлхий нийтийг хамарсан оюун санаа, соёл, мэдээллийн нэгдэлшлийн үзэгдэл, түрэлтийн томоохон орон зай, хүрээ нь тоон технологиор нөхцөлдсөн “үүлэн” сүлжээний агуулгын их сан, төвлөрөл болой. Дэлхий даяараа нэгэн зүйлийн тухай адил ойролцоо үзэл сэтгэлээр ярьж, бичиж, үзүүлж, түүндээ нийцсэн амьдралын хэв маяг үнэлэмжийг дээдэлж, тэр бүхнээ даган дууриах болсон нь мэдээллийн агуулгын нэгдлийн нөлөө, бас зорилго болоод байна.

Тэгээд ч сэтгүүл зүйн сүүлийн 30-аад жилийн хөгжил шинэчлэлт нь агуулгын нэгдэлшил, төвлөрлийг тэтгэсэн тоон технологи буюу бичвэр, дүрст тэмдэгт, дуу чимээ, өнгө хөдөлгөөнийг нэгэн орон зай өргөн зурваст нэгтгэх болсонтой холбон үздэг. Энэ нь бүх хэлбэр төрлийн мэдээллийг хялбар хэрэглэхэд амар байдлаар дурын хэрэгсэл төхөөрөмжид илгээх, хүлээн авах болсон гэсэн үг. Үүний үр дүн нөлөөгөөр ч олон сая компьютерийг холбосон Интернетийн сүлжээ дэлхий дахиныг нэгтгэж, тэр хүрээ нөлөөгөөрөө эгэл жирийн хүнээс улс орныг хүртэл эрхшээн эзэгнэх

болсон. Интернетийн мэдээлэл харилцааны орон зайд цаг хугацаа орон зай аливаа хязгаарлалт долгион сүлжээний ямар нэг зөвшөөрөл, мөнгө санхүү, төр засгийн элдэв дарамт аль нь ч үгүй хэн бүхэнд нээлттэй чөлөөтэйгөөр өөр хоорондоо агуулга тэмдэгтийн бүхий л хэлбэрийг солилцох, дамжуулах, хэрэглэх болсон нь нийгэм хүний амьдрал ертөнцөд цоо шинэ үзэгдлийг дагуулсан юм. Ийнхүү хүн байгаль ертөнц нийгмээс гадна виртуал хэмээх тэмдэгт сүлжээний орон зайд амьдрах болов. Энд цаг хугацаа, орон зай зэрэг байгаль бодит байдлын хууль, дүрэм, хүч хэмээх төрийн нөлөө хязгаарлалт гэж үгүй бөгөөд хүн өөрийн хүссэн, хүсч буй бүхий л дүр төрх, эрэлт сэтгэлээр амьдрах болсон юм. Мэдээж виртуал ертөнцөд хүний дүр төсөөлөл, үнэлэмж, сэтгэлгээ, байгаль ертөнц, нийгмийн ахуй төсөөллөөс эрс ангид биш ч тэдгээрт оршин үгүй олон “боломж сонголт”-ыг агуулж байдаг. Хүүхдүүд тоглоомоор, залуус нийгмийн сүлжээгээр, бүсгүйчүүд сурталчилгаагаар, эрчүүд видеоогоор дотоод ертөнц, далд ухамсрынхаа эрэлт хүсэлтийг хангаж, нийгэм төрөөс ангид оршин мөн чанараараа бүхнийг эзэгнэх болсон нь Интернетийн нэгэн увидас мөн.

Тийнхүү Интернет нь орчин үеийн хүний амьдралын хэв маягийн салшгүй нэгэн хэсэг болохын хэрээр нийгмийн харилцаа, сэтгүүл зүй, олон ниймийн соёл, цаашилбал эдийн засаг арилжаа санхүүгийн хөгжил, төлөвшилд бодитой нөлөөлөгч хүчин болов. Үүнд ОНМХ-ийн гурван том нэгдэлших үйл явцыг жишээлж болох бөгөөд тэдгээрийн үндэс суурь шалтгаан нь тоон технологи, гол нөлөө зорилго нь даяарчлал гэдгийг дахин тэмдэглэе. Судлаачид

мэдээлэл харилцааны нэгдэлших үйл явцыг технологийн, үйлдвэрлэлийн, сүлжээ түгээлтийн хэмээн гурван үндсэн хүрээнд томъёолдог.

Технологийн нэгдэлшил нь нэг талаас мэдээллийн суваг тогтолцоо (телевиз, сонин, радио) хоорондын, нөгөө талаас түгээх, хүлээн авах, дахин дамжуулах зэрэг хэрэглээний тоног төхөөрөмжийн (компьютер, гар утас, ipad) гэх мэт хүрээнд өрнөн агуулга ба тэмдэгтийн бүхий л хэлбэрийг нэгэн сүлжээнд эмхлэн, цаашлаад мэдээллийн хэрэгслийн төвлөрлийг хангах цөм хүчин болсон юм. Ийнхүү "мэдээлэгч-хэрэгсэл-хэрэглэгч" гэсэн харилцааны гурван үндсэн бие даасан ойлголт Интернет хэмээх сүлжээ, технологи агуулга үйлдвэрлэлийн нэгдмэл орон зайд нэгэн бүхэл цогц болон нэгтгэгдсэн хэрэг. Энгийнээр томъёолбол компьютер, мэдээллийн хэрэгслийн сүлжээ, харилцаа холбооны нэгдмэл орон зайд нэгтгэгдэн төвлөрөх агуулга тэмдэгтийн бөөгнөрөх үзэгдэл хэмээж болно. Энэ нь сансар огторгуйн их тэсрэлтийн дараах гариг эрхсийн нэгдэх үйл явцтай адилтгаж болмоор үзэгдэл бөгөөд тэнд татах хүч бүхний шалтгаан бол мэдээллийн ертөнцөд тоон технологи бүгдийг нэгтгэгч нь болой. Тэгээд ч тоон хэлбэрт ямар ч агуулга, тэмдэгт бие даасан мэдээллийн хэрэгсэл ба бусад тийм хүчин зүйлээс ангид, хараат бусаар оршин, түгэн тархах боломж, чанарыг олсон юм. Өөрөөр хэлбэл, технологийн нэгдэлшил нь хэрэгсэл сувгийн бус, харин тэмдэгтийн бие даан орших бүхэнд нээлттэй чөлөөтэй нэвтрэх, хэзээд хадгалагдах, нэгэнд нэгтгэгдэх, нөгөөг нэгтгэх чанар гэсэн үг юм. Тэгэхээр телевиз, радио сонин

Интернетийн орчинд нэгтгэгдсэн гэхээсээ тэдгээрийн агуулга, түүнийг тээгч тэмдэгтийн технологи нэгтгэсэн гэдэг нь зөв ойлголт юм. Энэ нь ч хэрэглэгчдэд бүхий л мэдээлэл агуулгыг нэгэн "дэлгэцээр" харах, унших, сонсох боломжийг нээсэн хэрэг. Сонин хэвлэл нь цаас, хар цагааны эрс тэсийн ялгаралд эрхшээгдсэн шриффт үсгийн тэмдэгтийн хэрэгсэл харин телевиз радио нь долгионы, телефон нь утас кабелийн хэрэглэгч хоорондын явцуу сүлжээний тоног төхөөрөмж байж дуу чимээ дүрсийг дамжуулж, хүлээн авдаг байсан.

Тийнхүү 1980-аад оноос холбоо харилцаа сансрын технологи компьютерийн техник, программ хангамжийн хөгжил шинэчлэлээр хэрэгсэл хоорондын тэмдэгтийн ялгац арилж, нэгтгэгдэх үйл явц эхэлсэн юм. Мөн энэхүү үйл явцад цэрэг зэвсгийн технологийн өрсөлдөөн, хууль эрх зүйн орчны өөрчлөлт, эдийн засаг санхүүгийн дэлхийчлэл нэн их нөлөөлснийг онцлох ёстой. Тухайлбал, "Цахиуртын хөндий" нь сансар, цөмийн зэвсгийн судалгааны төв байсан, холбоо харилцааны салбарын төвлөрлийг сааруулах зорилгоор тэдгээрийг мэдээллийн зах зээлд нэгтгэх боломжийг нээсэн эрх зүйн шинэчлэлтийг хийсэн, олон улсын харилцаанд улс орны эдийн засаг, санхүүгийн эрх ашгийг дээдлэх болсон, үндэстэн дамнасан компани, үйлдвэрлэгчид төрөн гарсан зэрэг нь тоон технологийн түрэлтийн гол үндэс шалтгаан нь юм.

Ийнхүү 1990-ээд оноос компьютер албан байгууллага, айл гэр, хүний өдөр тутмын хэрэглээ болтлоо тооны болоод чанарын хувьсал хийж даян дэлхийн сүлжээ, Интернетийн нөлөө

эрс өссөнөөр мэдээллийн хэрэгслийн нэгдэлшил бодит зүйл, зайлшгүй үзэгдэл болох суурь тавигдав. Дэлхий дахиныг хэрэн сүлжсэн Интернетийн орчинд тоон мэдээллээс гадна сонин хэвлэлийн хуулга мэдээ, гэрэл зураг, телевиз, радиогийн нэвтрүүлэг хөгжим үлэмж нэмэгдэн, компьютер харилцаа холбоо хэрэгслийн хэрэглээ эрэлтийг шинэчлэн тогтоов. Энд агуулгын өсөлт бичвэр зураг, дуу хөгжим, дүрст мэдээлэл, нэвтрүүлгээр төдийгүй, хувь хүний оролцоо, сонирхол харилцааны хүсэлт, хайлтаар ч өргөжин тэлэх болсныг хэлэх хэрэгтэй. Мэдээж бас мэдээлэл харилцааны салбарын эрх зүйн (1996 оны АНУ-ын холбоо харилцааны тухай хууль, 1997 оны Европын холбооны мэдээлэл харилцаа ба ОНМХ-ийн салбарын нэгдэл, мэдээллийн технологи, үр нөлөө зохицуулалтын ногоон ном) болоод үйлдвэрлэлийн шинэчлэлт, компьютерийн сүлжээнд нэгдэх зорилго боломжид тулгуурлах бодлого ч чухал хүчин зүйл байсан. Нэгдэлшлийн эхэн үеийн дүр зураг компьютер ба сүлжээний хүрээнд томъёологдож байсан бол 2000 оноос илүү бие даасан цогц ойлголт болтлоо хөгжиж өөрчлөгдөв. Ийм жишээнд Интернет телевиз, хөдөлгөөнт холбоо харилцааны үүрэн утасны үйлчилгээ, "таблет", зөөврийн хэрэгслийн контент нийлүүлэлт зэргийг тоочиж болно. Манай орны хувьд 2005 оноос "Цахим монгол" үндэсний хөтөлбөр хэрэг-

жүүлснээр Интернетийн хэрэглээ 18,8 дахин нэмэгдэж, давхардсан тоогоор 2,5 сая орчим иргэн үүрэн телефон хэрэглэдэг болжээ. Шилэн кабелийн сүлжээ 21 аймаг, 160 сумдад хүрснээр хүссэн мэдээллээ хаанаас ч олж авах нөхцөл бүрдээд байгаа ба үүрэн телефоны оператор компаниуд 2009 оноос 3G технологийг нэвтрүүлж, улмаар 4G технологийг нэвтрүүлэхээр нөөц бололцоо, эрэлт хэрэгцээгээ судлан төлөвлөж байна.

«
**Өдгөө технологийн хөгжил өсөн
 нэмэгдэж буй эрэлт хэрэгцээ,
 хүрээ нөлөөллөөс шалтгаалан
 хурдтай олон янзын хэлбэр,
 үйлчилгээнд зориулагдан
 шинэчлэгдэх болсон нь мэдээлэл
 агуулгын нэгдэлшилд зохирон
 нийцэгч шинэ сэтгүүл зүй
 хэрэгслийн эрин үеийг түрэх гол
 нөхцөл боллоо.**

Өдгөө технологийн хөгжил өсөн нэмэгдэж буй эрэлт хэрэгцээ, хүрээ нөлөөллөөс шалтгаалан хурдтай олон янзын хэлбэр, үйлчилгээнд зориулагдан шинэчлэгдэх болсон нь мэдээлэл агуулгын нэгдэлшилд зохирон нийцэгч шинэ сэтгүүл зүй хэрэгслийн эрин үеийг түрэх гол нөхцөл боллоо. Энэ бүхэн хялбар хэрэглээ, хямд үнэ, материаллаг сонирхлоор адилсан нийгэмших өргөн боломж, түгээмэл үнэлэмж, амьдралын хэв маягийн эрхшээл, эгшин зуурын хаа сайгүй орших сүлжээ зэргийг агуулж буйг тодотгохын хамт шинэ сэтгүүл зүйн хөгжлийн чиг хандлагын мөн чанар билээ. Мэдээллийн үйлдвэрлэлийн нэгдэлшил нь өөр хоорондоо нэлээд холбоо уялдаа бага **сэтгүүл зүй** (ОНМХ-ийн мэдээлэл, нийтлэл нэвтрүүлэг), **компьютер** (мэдээллийн технологи), **холбоо харилцааны үйлчилгээ** (дамжуулан түгээх, харилцах технологи) гэсэн

гурван үндсэн иж бүрдэл хэсгийн хүрээнд тодорхойлогддог.

Тиймээс мэдээлэл харилцааны шинэ зах зээл, хэрэглээний орчны дахин хуваарилалт, агуулгын нэгдэлшилд гүнээ эрхшээгдсэн технологийн үйлдвэрлэлийн давамгайлал, дэлхийн нийгэм, эдийн засгийн тоон дэг журмын засаглал эрх мэдлийн бүрэн ноёрхол зэргийг үйлдвэрлэлийн нэгдэлшлийн суурь үндэс хэмээн онцолдог. Энэ нь өнөөгийн даяар мэдээллийн үйлдвэрлэлийг нэг талаас уламжлалт хэрэгсэл суваг болох сонин хэвлэл, сансрын телевиз, богино долгионы радиогийн нийтлэл нэвтрүүлэг бүтээгдэхүүнийг нийлүүлэх нөгөө талаас ямар ч хэлбэр түвшинд зориулагдсан агуулга бүхий л тоног төхөөрөмж, технологийн хувьд түгээгдэх боломжтой байх гэсэн хоёр зорилгод үйлчлэх болсон. Өөрөөр хэлбэл, нэгэн суваг хэрэгслийн мэдээлэл (тухайлбал: сонины гэрэл зураг) нөгөөд нэвтрэх, олон нийтэд хүрэх технологи тэмдэгтийн нээлттэй боломж, орчныг бүрдүүлэхэд үйлдвэрлэлийн үр ашиг, зорилго оршиж буй хэрэг. Ийнхүү харилцаа холбоо компьютер болон мэдээллийн гурвалсан үйлдвэрлэлийн компанийн нэгдэл бий болов. Монгол Улсад IPTV үйлчилгээг 2011 оноос Юнивишн, 2012 оноос Скаймедиа компани нэвтрүүлж, GPON сүлжээгээ 100000 орчим айл өрх, албан байгууллагад хүргэж, 60000 гаруй хэрэглэгчтэй болоод байгаа нь энэ үйлчилгээ хэр эрчимтэй тархаж байгааг харуулж байна.

Эдгээрийг нэгтгэгч хүчин зүйл нь тоон технологи бөгөөд чухамхүү янз бүрийн түвшин тэмдэгтийн агуулгыг нэгэн суваг түгээх орчинд дамжуулах боломж нөхцөл бий болсон нь

үйлдвэрлэлийн нэгдэлшлийн гол шалтгаан гэдэг нь маргаангүй. Энэ нь мэдээллийг үйлдвэрлэх, түгээх, хүлээн авах гэсэн гурван том хүрээ нэгтгэгдэж нэгэн бүхэл цогц шугам болон төлөвшиж байгаа хэмээсэн үг юм. Тэгээд ч эдийн засаг, арилжааны зорилго, ашгийн хувьд эрс нааштай зэрэг үр дүн гарсан. Үүнд юуны өмнө олон дахин ашиглах, дахин дамжуулах, хавсарга нэмэлт болгох боломж бүхий тоон агуулгын үйлдвэрлэлийг хэмнэсэн, хэрэглэгчийн сонголт хайлт, эрэлтэд нийцүүлсэн түгээлтэд түшиглэснээр зардал буурсан, реклам захиалагчдад зорилгот идэвхтэй хэрэглэгчидтэй нь шууд олон янзын суваг, тэмдэгтийн нэгтгэгдсэн орчинд зар сурталчилгааг нь хүргэх санал хүсэлтийг биелүүлэх боломж бүрдсэн, мөн тэдэнд эргэх холбоот захиалах, шууд худалдан авах сүлжээний шинэ боломжийг бий болгосон зэргийг тоочих байна.

Ер нь мэдээллийн үйлдвэрлэлийн нэгдэл нь агуулгын нийлүүлэлт, түгээлт гэхээсээ түүгээр дамжин бодит зүйл болох материаллаг эрэлт сонирхлыг төлөвшүүлэх, хэрэглэгчдийн сэтгэл ханамжийг тэтгэх, хэрэглээг нэмэгдүүлэх, брэндийг дээдлэх зэрэг арилжаа худалдааны зорилгод чиглэж байна. Энд өмнө өгүүлсэн агуулгын нэгдэлшлийн өөр нэгэн учир шалтгааныг үйлдвэрлэлийн боломж хөгжил зорилгод буйг нэмэн тодотгох нь зүйтэй. Нөгөө талаар мэдээллийн нийгэм технологи мэдлэгт суурилсан эдийн засгийн мөн чанар нь хэрэглэгчийн үнэлэмж, хэрэглээ, сэтгэл ханамжийн нөлөө, байр суурийн ноёрхол эрхшээл болно. Тэгэхлээр хэрэглэгчийн дотоод ертөнцийг "Бүтээн байгуулагч" мэдээлэл, түүний үйлдвэрлэлийн

үнэ цэн, ач холбогдол өсөн бэхжих нь ойлгомжтой. Мэдээллийн үйлдвэрлэлийн хүрээ, түвшин ч эрс нэмэгдэн түүнээ үйлчлэх тогтолцоо нэгдэх болсон нь энэ цагийн нэгэн дүр зураг онцлог болох нь тодорхой.

Өргөн хүрээнд цогц байдлаар мэдээллийн бизнес нэгдэхийн хэрээр агуулгын нийлүүлэлт, боловсруулалт, бүтээхүйн орон зай, хүрээнд ч нэгдэлшил өрнөсөн юм. Үйлдвэрлэлийн үр ашиг хэмнэлтийг бий болгох зорилгод ч редакц байгууллагыг нэгтгэх нэгдмэл агуулга тэмдэгтийн орчинд нийцүүлэн зохион байгуулах үйл хэрэг ч өрнөв. Гэхдээ энэ нь цомхотгол хязгаарлалт биш бөгөөд үндэстэн дамнасан томоохон мэдээллийн үйлдвэрлэгчид ч өөртөө янз бүрийн хэрэгсэл байгууллагыг нэгтгэх бус, харин сүлжээний орчинд хамтран ажиллах уялдан зохицохуйц нэгж бүхий нэгэн цогц тогтолцоог бий болгохыг эрмэлзэж байна. Тиймээс мэдээллийн үйлдвэрлэлийн нэгдэлшлийг байгууллага редакц хэрэгслийн гэхээсээ зорилго, хэмнэлт, ашгийн төлөөх уялдаа зохицлын төвлөрсөн бус нэгдэл хэмээн тодотгох хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, улам бүр өргөжин тэлж буй мэдээллийн үйлдвэрлэлийг эрэлт нийлүүлэлтээр алсарч буй бие даасан нэгжүүдийн технологи зорилго зайлшгүйд эрхшээгдсэн "мэдээллийн нийгэм, даяар, сүлжээ" эс төвлөрлийн мөн чанарт даяар нэгдэлшил гэж томъёолж болно. Энэхүү хачин томъёоллыг хүүхэлдэйн киноны график дүрслэлээр жишээлэхэд зураач, программ зохиогч, компьютерийн үйлдвэрлэгч, найруулагч, жүжигчин, продюсер гээд бүхий л хүчин зүйлийн хүрээнд олон янзын нарийн мэргэжлийн байгууллага, мэдлэг, хүний оролцоо,

өсөн нэмэгдэж буй байдал хийгээд тэд ашиг орлого брэнд бүтээх нэгэн зорилгын дор мэдээллийн бүхий л хэрэгсэл, суваг, сүлжээнд нийцүүлэн нэгдэх, уялдаа зохиролд ажиллах болсон зэргээр тоймлож болох юм. Нэгтгэн дүгнэвэл мэдээллийн үйлдвэрлэл нэгдэлшихийн хэрээр улам олон үйл хүчин зүйлээс шалтгаалах болж, тийнхүү эрхшээгдэхийн шалтгаанаар өөр хоорондоо илүү хараат хамаарал бүхий нэгдмэл тогтолцоог төлөвшүүлж байна.

Ийм нэгдлийн жишээнд Time Warner AOL, Universal picture, News Corp, PIXAR зэрэг олон компанийн бүтэц зохион байгуулалт, бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, амжилт шинэчлэлтийг тэмдэглэж болно. Тиймээс ч тэр бүхнийг яг таг нарийн тодорхойлох боломжгүй бөгөөд өргөн хүрээнд үргэлжийн хөдөлгөөн өөрчлөлт дунд бүтээгдэхүүн бүрийн онцлог зорилгоос шалтгаалан өөр өөрөөр тодорхойлогддог болно. Харин ашиг орлого, даяар мэдээллийн урсгалд нийцэх, хүний материаллаг бус үнэлэмж, сэтгэл ханамжийг бий болгох зорилгын тухайд бол нэгэн цогц үйлдвэрлэгчийн зохион байгуулалтад нэгддэг.

Түүнчлэн компьютер, холбоо харилцааны томоохон компаниуд ч мэдээллийн зах зээл рүү түрэх, байр сууриа бэхжүүлэх боллоо. Үүний анхны томоохон үйл явц нь мэдээллийн кабелийн телевизийн MSNBC (1996) суваг бөгөөд түүнийг Microsoft, NBC гэсэн хоёр том компани байгуулсан юм. Өдгөө ийм нэгдэл жишээ олон ба хамгийн дуулиантай нь 2006 онд Интернет хайлтын "аварга" GOOGLE видео агуулгын YOUTUBE сайтыг 1.65

тэрбум доллараар худалдаж авсан нь болой. Ийнхүү өгүүлбэл олныг дурдах ба өнөөдөр ч үйл явц ид өрнөж байгаа бөгөөд хамгийн гол нь нэгдэлшлийн зорилго нь мэдээллийн бүхий л бүтээгдэхүүнийг (мэдээ, зураг, кино, хөгжим гэх мэт) эргэх холбоо, эгшин зуурын, тоон сүлжээт орчинд нийлүүлэхэд оршино.

Мэдээллийн технологийн хөгжил, өөрчлөлтийн нөлөө нь нэгдэлшил, даяарчлалын өргөн хүрээтэй үзэгдлийг дагуулахын хамт агуулгын үйлдвэрлэлийн дотоод зохион байгуулалт, бүтцийг улам бүр бие даасан, уялдаа холбоотой олон нэгж бүхий болгох нөхцөл шаардлагыг бодит зүйл болгосныг дахин тэмдэглэе. Мөн нийгэмшүүлэл (зугаа цэнгэл), спорт, кино, хөгжмийн бизнес, зах зээлийн салбар хамгийн ашиг орлоготой, өрсөлдөөнтэй, эдийн засгийн нөлөө, эрх мэдлээр тэргүүлэгч "агуулгын ертөнц" болон төлөвшив. Тэгээд ч компьютер, программ хангамж, электрон бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн технологи, хөгжим нь харахуйн мэдээллийг хэрэглэгчдэд илүү амьд, хүчтэй сэтгэгдэл төрүүлэхүйц Интернет сүлжээнд шууд, хялбар холбогдох зорилгод чиглүүлж байна.

Нэгдэлшил өөрчлөлтийн гурав дахь хүрээ, үйл явц нь мэдээллийн түгээлт, хэрэглээ, сүлжээний орчинд өрнөж байна. Тэгээд ч даяар сүлжээний нөлөө, түрэлтийн өсөлтийг зөвхөн сэтгүүл зүй, мэдээллийн салбарт бус, нийгэм, улс төр, эдийн засгийн өргөн хүрээнд хүлээн зөвшөөрч, олон үзэгдэл, өөрчлөлтийн үндэс шалтгаан, цаашдын өрнөлийн суурь хэмээн үзэх болов.

Эдийн засгийн түүхээс л тоймлоход анхны томоохон сүлжээ нь "торгоны

зам" байсан ба түүгээр бараа бүтээгдэхүүн ашиг орлого мөнгө төдийгүй соёл, технологи, хэрэглээ түгээгдэж байсан гэдэг. Гэхдээ энэхүү сүлжээ нь "тэмээн жингийн" хурдтай, торго, шаазан, алт гэсэн цөөн хязгаарлагдмал бараа бүтээгдэхүүний хүрээнд, дайн, дээрэм, татварын тодорхойгүй байдлын үлэмж дарамт дор, худалдаа арилжааны явцуу орон зайд хөгжиж байв. Мэдээллийн гол харилцаа нь аман харилцаа, агуулга нь үлгэр домог, хууч дурсамж яриа, зарим нэг бичмэл тэмдэглэл төдий байсан ба хамрах хүрээ, орон зай нь ч маш бага, өгүүлэгчийн хэтрүүлэл, бодит бус, төөрөгдөл хэтийдлийн жишээ дүүрэн байв. Мөн харилцааны орчин нь хаалттай, нууцлагдмал байсан ч өсөн дэвжих боломж нөхцлийг хааж, нийгэм хүмүүний амьдралын хэв маягт үзүүлэх нөлөөг хязгаарлаж ирсэн хэрэг.

Хүн төрөлхтний эдийн засаг арилжааны дараагийн сүлжээт усан замын тээвэр, далбаат хөлөг бий болгосон. Худалдаа, арилжааны хурд, хэмжээ өсч, улс төр, цэргийн бодлогын хүч нөлөөг өргөж газарзүй, одон орон, математик, геометр зэрэг байгалийн шинжлэх ухаан хөгжин шашин, сүсэг бишрэлийг ганхуулж, тивүүд дамнасан их нээлт хүний оюун ухаан, мөн чанарын тухай олон эргэлзээ, шинэтгэлийг дагуулав. Ийнхүү анхны сонин, мэдээллийн хуудас, ном зохиол дэлхийн нийгмийн харилцаанд хүндтэй байр суурийг эзлэв. Мэдээ мэдээллийг арилжаа, хэрэглээний зорилгоор олон нийтэд түгээх болсноор харилцааны нийгмийн байр суурь нөлөө өөрчлөгдөж, хүмүүсийн соёл, амьдралын хэв маягт шинэ орон зайг бий болгов. Сэтгүүл зүйн

үүрэг нөлөө ч өсөн тэлж, улс төр нийгмийн амьдралын "гол тоглогч" болон хувьсгал, шинэчлэлийн хүчирхэг хөдөлгөгч, оюун санааных нь эзэнд өргөмжлөгдсөн түүхийг бид мэднэ.

Харин дараагийн сүлжээг төмөр зам, цаашлаад агаарын тээвэр бий болгон радио, телевиз, холбоо харилцааны шинэ хэрэгсэл (телефон, телеграмм, сансрын хиймэл дагуул) мэдээллийн түгээлт, нөлөөллийн хүрээ, түвшинг шинэчлэв. Олон нийтийн соёл, хэрэглээ, байр суурь урьд өмнө байгаагүйгээр өсч, дүр төрх, загвар дизайн хэв маягийн адилсал, дууриаллын үнэлэмж бүхнийг нэгтгэв. Улс төрд бодлого хөтөлбөрөөс илүү нэр дэвшигчийн имиж, эдийн засагт түүхий эд, эрэлтээс илүү нэр, сав, баглаа, өнгө, нийгмийн амьдралд туйлын төгс итгэл бишрэлээс илүү цаг үеийн харьцангуй давуу байдал чухал, зонхилгоч хүчин зүйлс болсон юм. Сэтгүүл зүй мэдээллийн бизнесийг шинэчлэн өөрчлөгдөж байсны нэгэн үндэс шалтгаан нь сүлжээ түүнийг тодорхойлогч байсныг өгүүлэх юун. Телевизэд сансрын технологи нэвтэрснээр мэдээллийн нэвтрүүлэг хөтөлбөрийн эрэлт сонирхол өсч хүмүүс уран сайхныг бус баримтат гэхдээ хэрэглээ, адилсал дуурайллын "үнэ цэнтэй" агуулгыг эрхэмлэх болжээ. Ийнхүү түүхэн хүний тухай баримтат нэвтүүлэг, реалити хөтөлбөр, үзэгчдийн шууд оролцоо бүхий хэлэлцүүлэг, ярилцлага телевизийн дэлгэцнээ ноёрхож, цаг үе нийгмээ ойлгох, дүгнэхүйн хүний ертөнцийн "луужин" болов.

Мэдээллийн даяар сүлжээ нь үндэстэн дамнасан компани, эдийн засгийн тогтолцооноос ангид, бие даан оршиж, хөрөнгө мөнгө, төвлөрлийн бус, харин мэдлэг мэргэжил, уян хатан

шинэчлэлт, нэгэн хэсгийн нөлөө байр суурийг бэхжүүлж буйг онцлох ёстой. Сүлжээ нь өөрийн дэг журам, логик, зарчимтай бөгөөд тэр нь байгаль, нийгмийн хэм хэмжээнээс үл хамааран, эс төвлөрөлт эргэх холбоо бүхий байх, агуулгаасаа илүү сүлжээнд байх хэлбэршил нь чухал болох, даяар орчинд бие даасан, хувь хүнийхээрээ ондооших (сонголт, хайлт, далд байдал) хэрэглээ, эрэлт сонирхолд үйлчлэх зэрэг мөн чанарын илэрхийлэл болой.

Өдгөө хөрөнгө мөнгөтэй томоохон үйлдвэрлэгчийн өрсөлдөгч нь эн тэнцүү ямар нэгэн компани бус, харин сүлжээнд баттай нөлөө байр сууриа эзэлсэн шинэ оролцогч бүр хэн нэгэн мэргэжилтэн болсон, их гүрний "айдас" нь цэрэг зэвсэг бүхий ямар нэгэн улс биш хэдхэн хүн ажилладаг мэдээллийн сайт (WIKILEAKS), бүр хувь хүнээс (Сноуден) шалтгаалж байгаа зэрэг нь даяар сүлжээний мөн чанартай холбоотой. Өөрөөр хэлбэл нийгмийн, олон нийтийн гэсэн өмнө нь хамгийн нөлөө хүч бүхий чанар өнөөдөр үгүйсгэгдэж хувь хэрэглэгчийн мэдлэг мэдээлэлтэй бүлэг хэсгийн сонголт оролцоо идэвх бүхнийг тодорхойлж байна гэсэн үг. Сонин хэвлэл, телевиз радиогийн ч нийгмийн мэдээлэл харилцааны тогтолцоо байх гэсэн тэргүүлэгч байр суурь зорилго өөрчлөгдөж, даяар сүлжээний хэл эрэмбэ тэмдэгтийн стандарт нэвтрэх боломжид илүү бодитой бүрэн нэгтгэгдсэн, түүний дэг журам, зарчимд нийцсэн, хэрэглээ мөн чанарт нь үйлчилсэн агуулга, үйл хэлбэрийг дээдлэх болсон нь санаандгүй хэрэг биш. Тэгэхлээр мэдээллийн хэрэгслийн хөгжил өөрчлөлтийг нэг

талаас хэт бэтгэдэл хэрэглээний эдийн засаг, нийгмийн нөлөө түрэлт нөгөө талаас сүлжээний орчны бие даасан харилцаа хэм хэмжээний дэг журам, зайлшгүйгээр тайлбарлах учиртай.

Ер нь мэдээллийн даяарчлал гэдэг нь орон зайн ойлголт бус, харин үйл явц, үзэгдэл "хөдөлгөөн"-ий тухай нэр томьёо юм. Тиймээс мэдээллийн эрэлт хэрэглээний агуулгын чанараас (ур чадвар, хэл найруулга, өгүүлэмж) илүү хэлбэр илэрхийлэл (тоон технологийн боломжийг бүрэн ашиглах) чухал болж, бодит ертөнц, үйл явдлыг мэдээллэх төдийгүй, тэмдэгт сүлжээний өөр нэг бие даасан ахуй, "нийгэм"-ийг бий болгов. Хүмүүс улам бүр даяар, нэгдмэл харилцааны орон зайд буйгаа мэдрэхийн хэрээр сонголт, хайлт, хэрэглээгээрээ алслагдан тусгаарлагдах болов. Тэгээд ч эс олон нийтших хандлага, эргэх холбоот хэрэглээ, сонголт, хайлтын харилцаа, виртуал, тэмдэгтийн үнэлэмж дээдлэл, хувь хүнийхээрээ байх эрмэлзлэл, эрэлт энэ бүхэн даяар сүлжээний сэтгүүл зүйг тодорхойлж байна. Даяар сүлжээний мэдээллийн эрэлт, нийлүүлэлт ч эрс өөрчлөлт, санаандгүй үр дагавар, зүй бус зохицуулалт дор төлөвшин технологийн шинэ шинэ ололт нээлтийг эрэлхийлэх болов. Харилцаанд нэгтгэгдэхийн хэрээр "хүн, технологи, хэрэглээ" гэсэн гурван хүчин зүйл улам бүр даяар сүлжээнээ эрхшээгдэн, тэр хэрээр түүний тэмдэгт, дэг журам, зарчимд эрх мэдлээ шилжүүлэн байна.

Сүлжээний орон зай хэмжээлшгүйн адил цаг хугацаа нь ч хязгааргүй бөгөөд төр, нийгмийн ямарваа нэг хяналт, зохицуулалт гэж үгүй "ертөнц" билээ. Эдийн засгийн онолчид мөнгө, хэл, зах гурвыг төрөөс өмнө бий

болсон, өөрийн зохицуулалт бүхий, хүн нийгмийн мөн чанарын уг сурвалж гэдэг. Тэгвэл харилцаа нь нийгмээс ч өмнө байсан ба хүний нэгдлийн сүргийн амьдралыг иргэншүүлсэн гол хүчин зүйл хэмээн үзвэл зохино. Нийгмийг төлөвшүүлэн тогтоодог багана нь дэг журам (хууль, ёс зүй) үнэлэмж (итгэл үнэмшил, шашин, үнэт зүйлс) ба тэдгээрийн оршихуйн тэтгэгч нь харилцаа мөн. Тэгэхлээр өнөөгийн даяар сүлжээний хүч нөлөөг харилцаатай холбон тайлбарлах нь зөв бөгөөд энэхүү дүгнэлтэд Интернет сэтгүүл зүй ч адил багтана.

Либерал сэтгүүл зүйн үзэл номлолд төр, нийгэм, хүний эрх чөлөө, хяналт нөлөөллийн асуудлыг онцлон үзэж, төрийн хязгааргүй эрх мэдлийг хүний бие даасан байдал, төрөлх эрхийг дээдлэх зарчмаар хязгаарлах, харин хүний төгсөшгүй хүсэл шунал, гажуу хэтийдлийг нийгмийн эрх ашгийн хүлцэн тэвчихүйг бүх нийтээр хүлээн зөвшөөрснөөр хазаарлах, нийгмийн амьдрал, харилцааг зүй зохист дэг, хэм хэмжээнд нэгтгэхэд төрийн засаглал, үүргийг хуульчилахад оршино гэсэн гурвал томьёололд үздэг. Энэхүү онол төр хүчтэй, нийгмийн нөлөө байх суурь бэхжин төлөвшиж байсан сонины эрин үед нэн бодитой нийцэж, радио телевизийн хөгжил ирэхэд "засварлагдаж" нийгмийн өмнө хариуцлага хүлээх гэсэн шинэ ойлголтоор баяжиж байв.

Харин Интернет, даяар сүлжээний мэдээлэл харилцааны цаг ирэхэд төр нь үндэсний эдийн засгийн хяналтаа алдах, улс төрийн бодлого, байр сууриа үндэстэн дамнасан компани болон бүр сэтгүүл зүйд "шилжүүлэх", хямд ажиллах хүчийг дэмжин оршдог

нөлөө нь ганхах, хүчний болон татварын тогтолцоогоор дамжин хэрэгждэг эрх мэдэл нь нийгмийн ухаалаг хэрэглээ, ухамсар өссөнөөр буурах зэрэг бодит хүчин зүйлээс шалтгаалан "жижгэрэх" болсон юм. Ийнхүү либерал сэтгүүл зүйн хүний эрхийн дээдлэлээр дамжуулан төрийг хянах үүрэг "утгагүй" болж, харин нийгмийн амьдрал харилцаанд үйлчлэх зорилго, байр суурь нь эрс нэмэгдлээ. Тиймээс сүлжээний сэтгүүл зүй илүү нийгмийн "эд эс" байх, хувь хүний сонголт эрэлтээр тодорхойлогдох технологи, хэрэглээнд бүрэн эрхшээгдсэн үйл, харилцаа болов.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Болд-Эрдэнэ Б. 2006. Олон нийтийн харилцаа. УБ.
2. Болд-Эрдэнэ Б. 2009. Интернет сэтгүүл зүй. УБ.
3. 2008. Интернет хэрэглэгчийн гарын авлага. УБ.

4. Зулькафиль М. 2005. Сэтгүүл зүйн товч тайлбар толь. УБ.

5. Зулькафиль М. 2007. Орчин үеийн сэтгүүл зүй. УБ.

6. Норовсүрэн Л. 2003. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм. III боть. УБ.

7. Цэмбэл Д., Цэнджав До., Дагиймаа Д., Ариун Л. 2005. Электрон сэтгүүл зүй. УБ.

8. 2010. Интернет СМИ. Под ред. М.М. Лукиной. М.

9. Коханова Л. 2007. Интернет-журналистика. Москва.

10. Черных А. 2001. Мир современных медиа. Москва.

11. Ward M. 2002. Journalism online. N. Y.

Резюме

В настоящей статье автор предпринял попытку интерпретации аспектов развития и становления Интернет-журналистики, опираясь на факторы единства технологии, содержания и сети. Как считает автор, эти факторы являются основной движущей силой, определяющей тенденцию трансформации и эволюции социальных и межличностных отношений.